



ASI МОНГОЛ ХОЛБОО

ТАНИЛЦУУЛГА БА ДҮРЭМ

2024.10.01

УЛААНБААТАР ХОТ

- Бидний түүх
- Эрхэм зорилго
- Алсын хараа
- ASi холбооны стратеги төлөвлөгөө
- Үндсэн хууль, дүрэм



Доктор Эдвард Александр Сатерланд нь ASi холбооны үндэс суурийг тавьсан чухал эрхмүүдийн нэг юм. Э.А Сатерланд нь 1904 оны 6-р сард Эммануэл номлогчийн коллежийн ажлаа өгч Элен Уайт, П.Т. Магэн болон бусад гишүүдийн хамт залуучуудад зориулсан шинэ сургууль байгуулахаар тохиромжтой газар хайж, Камберланд голоор урд зүгийг чиглэн хамтдаа завиар явж байлаа. Гэтэл гэнэт завь нь эвдэрч голын эрэг рүү гарах шаардлагатай болов. Тухайн завь эвдэрсэн газарт нэгэн том эдлэн газрыг зарна гэсэн байсан бөгөөд тэд хамтдаа тухайн газрыг үзэж сонирхжээ. Энэ үед Элен Уайт “Би энэ газрыг үзэгдлээр үзсэн, энэ газар бидний хайж байгаа газар мөн байна.” гэж итгэл дүүрэн бусдадаа хэлэв. Харин Сатерланд болон Магэн нарт тухайн газар тийм ч тохиромжтой санагдаагүй бөгөөд тэдний хувьд хөршүүдтэйгээ ойролцоо жижиг газар хайж байсан тул тухайн газрыг орхиж эрлээ үргэлжлүүлсэн байна.

Дараа өдөр нь Элен Уайт тэдэнд өмнөх газрыг ахин санал болгож, тухайн газрыг үзэгдлээр үзсэн тухайгаа хэлж тэдэнд учирлав. Ингээд Сатерланд болон Мэган нар тухайн газрыг ахин очиж үзэхээр болж хэдий өөрсдөд нь таалагдаагүй ч Элэн Вайтын үзэгдэлд итгэж, тухайн газрыг худалдан авахаар болсон байна. Ийнхүү Америкийн нэгдсэн улсын Тенниси мужийн Нашвил хотын ойролцоо Мэдисон Коллеж сууриа тавьсан түүхтэй.

Цөөн хэдэн суралцагчтай эхэлж байсан ч богино хугацаанд нийгэмдээ танигдаж, олон суралцагчтай болсон нь Адвентист Ерөнхий Чуулганы анхаарлыг татсан байна. 1946 оны Ерөнхий Чуулганы хурал болох үед Мэдисон сургууль аль хэдий нь 50 гаран нэгжтэй болсон байсан бөгөөд нь Хойд Америкт өөрийгөө дэмжигч ажилчдын комиссыг байгуулж, Ерөнхийлөгчөөр нь Э.А Сатерландыг томилсон юм. Ийнхүү дараа жилийн хавар буюу 1947 оны 3-р сард Ерөнхий Чуулганы хуралдаанаар ASi (The Association of Self-Supporting Institutions – Өөрийгөө дэмжих холбоо) албан ёсоор байгуулагдсан байна. ASi холбооны эхний уулзалтаар Элен Уайт “Сүмийн удирдлагууд болон ажилчин ангийнхан хамтарч ажиллахгүй бол энэ дэлхийн төгсгөл хэзээ ч ирэхгүй.” гэж анхааруулан хэлж байжээ.

ASi холбооны үндсэн зорилго нь сүмийн ажилчид болон ажилтан ангийнхныг нэгтгэж Долоо Дахь Өдрийн Адвентист сүмийн үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд оршиж байв. Ийнхүү холбооны үйл ажиллагаа нь Адвентист бизнес эрхлэгчид болон мэргэжилтнүүд дунд илүү хурдтай түгэн дэлгэрснээр 1979 онд албан ёсоор Adventist-laymen's Services & Industries /Адвентист ажил эрхлэгчдийн үйлдвэрлэл, үйлчилгээ/ болгон өөрчилсөн байна.

Өнөөдөр ASi холбооны бизнес эрхлэгч, мэргэжилтнүүд болон Долоо дахь өдрийн Адвентист сүмийн үйлчлэгч, ахлагч нар хамтдаа Бурханы сайн мэдээг дэлхий дахинаа түгээн дэлгэрүүлсээр байна.

ХРИСТИЙГ ДЭЛХИЙД ТҮГЭЭХ:

1 Коринт 1:1-д Паул өөрийгөө: «Бурханы хүслээр Есүс Христийн элч болохоор дуудагдсан Паул би» гэж тодорхойлсон бөгөөд майхан оёхын зэрэгцээ Бурханы баярт мэдээг бусдад тунхаглаж байв.

ASi-чууд бид Матай 28:19 "Иймээс явж, бүх үндэстнийг дагалдагч болгогтун. Эцэг, Хүү, Ариун сүнсний нэрээр тэдэнд баптизм хүртээж, Миний та нарт тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл би та нартай үргэлж хамт байх болно гэж айлдав." Гэх агуу даалгаврыг хэрэгжүүлэхээр дуудагдсан гэдэгт итгэдэг.

ЭРХЭМ ЗОРИЛГО:

ASi холбоо нь ажил мэргэжил, үйлдвэрлэл, боловсрол, үйлчлэлд оролцдог Долоо дахь өдрийн Адвентист гишүүдийн үүсгэсэн холбоо бөгөөд Христийг хуваалцах зорилгыг эрхэмлэж, ажил эрхлэгчдэд боломжийг үүсгэхийн зэрэгцээ Долоо дахь өдрийн Адвентист сүмийн эрхэм зорилгыг дэмжиж ажиллах зорилготой.

АЛСЫН ХАРАА:

ASi холбооны гишүүд бизнес, үйл ажиллагаагаа үнэнч шударгаар гүйцэтгэж, сүмийн төрөл бүрийн үйлчлэлд идэвхтэйгээр оролцож, сүмийн удирдлагыг эргэлзэлгүйгээр дэмжиж, бусдын хэрэгцээг хангаж, ажил үйлсээрээ Христийг эрхэмлэдгээрээ нийгэмд танигдах юм.

УРИА:

"Ажлын талбарт Христийг хуваалцах."

ҮНЭ ЦЭН:

Дараах гурван үнэт зүйл нь бидний хийж байгаа эсвэл хийхийг оролдсон бүх зүйлд гол байр суурь байх болно.

- I. Адвентист Сүм ба түүний эрхэм зорилгод үнэнч байх
- II. Бизнесийн үйл ажиллагаагаа ёс суртахуунтай явуулах, өргөжүүлэх
- III. Үйлчлэлд идэвхтэй оролцох

СТРАТЕГИ:

Эрхэм зорилгоо биелүүлэхийн тулд доорх гурван стратегийг баримтлан ажиллана.

- I. Бурханы гэрчлэлээр дүүрэн, мартагдашгүй, нэгдмэл, мэргэжлийн түвшинд чуулга уулзалтуудыг зохион байгуулах.
- II. Бид Христийн үүрэг даалгаврыг шинэлэг, нэгдмэл байдлаар хэрэгжүүлнэ.
- III. Бид ирээдүйн удирдагчдыг бэлтгэхийн зэрэгцээ гишүүнчлэлийг нэмэгдүүлж, хүчирхэгжүүлнэ.

ASi МОНГОЛ ХОЛБООНЫ ЗАСАГЛАЛ:

ASi Монгол холбооны ТУЗ нь 7 хүний бүрэлдэхүүнтэй байна.

- I. Ерөнхийлөгч /Гадаад харилцаа давхар хариуцах/
- II. Нарийн бичиг /Дотоод үйл ажиллагаа давхар хариуцах/
- III. Санхүүч /Спонсор давхар хариуцах/
- IV. Баярын мэдээ ба сүнслэг байдал хариуцсан захирал
- V. Гишүүд ба Орон нутаг хариуцсан захирал
- VI. Төсөл хөтөлбөр ба Маркетинг хариуцсан захирал
- VII. Шагнал урамшуулал ба зочид төлөөлөгчид хариуцсан захирал

AS МОНГОЛ ХОЛБООНЫ ҮНДСЭН ХУУЛЬ БА ДҮРЭМ

2024 оны 10 сарын 01

1-Р ЗҮЙЛ НЭР:

Байгууллагын нэр нь: ASi Монгол Холбоо

ASi Монгол Холбоо нь Хойд Ази, Номхон Далайн бүсийн ASi холбоо /NSD ASi/-д хамаарагдах бөгөөд NSD ASi холбооны удирдлага дор, Монгол Улсын Төрийн Бус Байгууллагын хууль дүрмийг баримтлан ажиллана.

2-Р ЗҮЙЛ ХОЛБООНЫ ЗОРИЛТУУД:

2.1 NSD ASi холбооны удирдлага дор Долоо Дахь Өдрийн Адвентист сүмийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах.

2.2 Адвентист сүмийн бизнес эрхлэгч, мэргэжилтэн, ажилтан, хамт олны ойр орчмын хүмүүст Бурханы баярт мэдээг түгээхэд дэмжлэг үзүүлэх.

2.3 Адвентист бизнес эрхлэгчдийг Адвентист сүмүүдтэй, Адвентист Чуулгантай, чуулганы хамаарал бүхий аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах, биеэ дэмжин ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх.

2.4 Адвентист бизнес эрхлэгчдийг мэдээ мэдээллээр хангах, хоорондоо хамтран ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх, өөрсдийн үйл ажиллагааг сайжруулахад дэмжиж ажиллах.

2.5 Долоо дахь өдрийн Адвентист Сүмийг дэмжих төслүүдэд зөвлөгөө өгөх, сурталчлах, санхүүжүүлэх замаар туслах.

3-Р ЗҮЙЛ ГИШҮҮНЧЛЭЛ:

3.1 ASi Монгол холбоо нь хувиараа бизнес эрхлэгч, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч, компанийн ажилтан, бизнес эрхлэхээр төлөвлөж буй эсвэл сонирхож буй Адвентист сүмийн гишүүн бүрд нээлттэй.

3.2 ASi Монгол холбооны гишүүн нь Монголын Адвентист Чуулганы албан ёсны ажилтан байж болохгүй.

3.3 ASi Монгол холбооны гишүүн болох хүсэлтэй сүмийн гишүүд холбооны дүрэмтэй танилцаж хүлээн зөвшөөрсний үндсэн дээр доорх төрлүүдээс сонголт хийж гишүүнээр бүртгүүлнэ.

I. Компанийн гишүүнчлэл: Энэхүү ангилалд хоёр ба түүнээс дээш ажилтантай компани хамаарах бөгөөд ASi Монгол холбооны үйл ажиллагаанд компанийг төлөөлж нэг хүн оролцуулах эрхтэй. Нэгээс дээш хүн оролцуулах тохиолдолд тухайн үйл ажиллагааны төлбөрийг төлнө.

II. Энгийн гишүүн: Энэхүү ангилалд Адвентист сүмийн бизнес эрхлэгч, сонирхогч, бизнес эрхлэгч байсан, компанийн ажилтан зэрэг хүмүүс хамрагдана.

III.Хүндэт гишүүн: Энэхүү ангилалд ASi Монгол холбооны үйл ажиллагааг дэмжих зорилгоор гишүүнчлэлийн төлбөрийг хоёр дахин ба түүнээс дээш дүнгээр хандив тусламж өгсөн гишүүд хамрагдах юм.

3.4 Гишүүн нь гишүүнчлэлийн эрхээ баталгаажуулахдаа: "Бурханы хүслээр Есүс Христийн элч болохоор дуудагдсан би ASi Монгол холбооны гишүүний хувьд ASi Монгол холбооны эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн тулд холбооны зүгээс зохион байгуулж буй үйл ажиллагаанд гар бие оролцож, идэвх санаачилгатай байхаа тангараглаж байна." хэмээн тангараг өргөнө.

3.5 Гишүүн нь тангараг өргөснөөр албан ёсны гишүүн болно.

4-Р ЗҮЙЛ ГИШҮҮНИЙ ЭРХ:

4.1 ASi Монгол холбооны гишүүн нь холбооны зүгээс зохион байгуулж буй үйл ажиллагаанд үнэ төлбөргүй оролцох эрхтэй. Энэ нь гишүүд үнэгүй хамрагдах үйл ажиллагаа байна.

4.2 ASi Монгол холбооны гишүүн нь бүх гишүүдийн хурал, сургалт болон бусад үйл ажиллагаа дээр өөрийн санал бодлоо илэрхийлэх эрхтэй.

4.3 ASi Монгол холбооны гишүүн нь Удирдах зөвлөлийн гишүүнд нэрээ дэвшүүлэх, өөрт болон бусад гишүүдэд санал өгөх эрхтэй.

4.4 ASi Монгол холбооны гишүүн нь холбооноос зохион байгуулж буй бүх үйл ажиллагаанд гишүүн бус хүнээс давуу эрхтэй байна.

4.5 ASi Монгол холбооны гишүүн нь Удирдах зөвлөлд шаардлага тавих эрхтэй.

4.6 ASi Монгол холбооны гишүүн нь гадаад улс оронд зохион байгуулагдах ASi холбооны зүгээс зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд оролцох эрхтэй.

ГИШҮҮНИЙ ҮҮРЭГ:

4.6 ASi Монгол холбооны гишүүн нь холбооны зүгээс зохион байгуулж буй бүх үйл ажиллагаанд идэвхтэй оролцох үүрэгтэй.

4.7 ASi Монгол холбооны гишүүн нь гишүүнчлэлийн төлбөрөө заагдсан хугацаанд төлөх үүрэгтэй.

4.8 ASi Монгол холбооны гишүүн нь холбооны дүрэм журмыг дагаж мөрдөх үүрэгтэй.

5-Р ЗҮЙЛ САНАЛ БА СОНГУУЛЬ:

5.1 ASi Монгол холбооны удирдах зөвлөлийг сонгох сонгуульд зөвхөн төлбөр төлсөн албан ёсны гишүүн санал өгөх эрхтэй.

5.2 Гишүүн бус хүн санал өгөх эрхгүй бөгөөд зөвхөн санал, зөвлөмж, санаа, шүүмжлэл хэлэх эрхтэй боловч ТУЗ болон албан ёсны гишүүд давуу эрхтэй байна.

5.3 ТУЗ-ийн гишүүдийг сонгох бүх гишүүдийн хурал хоёр жил тутамд явагдах бөгөөд ТУЗ-ийн гишүүдийг сонгож баталгаажуулсан өдрөөс эхэлж хоёр жилийг тооцно.

5.4 ТУЗ-ийн гишүүд олонхын саналаар улиран сонгогдох эрхтэй.

5.5 Бүх гишүүдийн хурлыг холбооны Ерөнхийлөгч ахлан явуулах бөгөөд хурлын зөвлөлд ASi Монгол холбооны зохицуулагч эсвэл Адвентист чуулганаас хөндлөнгийн хянагчийг оролцуулна.

5.6 ТУЗ-д сонгогдох гишүүд нь ASi Монгол холбоонд үйлчлэх өөрийн хүсэл эрмэлзэлтэй байх шаардлагатай. Хэрэв тухайн гишүүн өөрөө ТУЗ-д орох хүсэлгүй хэдий ч олонхын санал авсан бол тухайн гишүүнийг удирдах зөвлөлд сонгохгүй.

5.7 Бүх гишүүдийн хурал болон ТУЗ-ийн хурал 51% - с дээш ирцтэй байж хуралдах эрх үүснэ.

6-Р ЗҮЙЛ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН АЖЛЫН ЭРХ ҮҮРЭГ

6.1 ТУЗ -ИЙН ГИШҮҮДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

I. Бизнес эрхлэгч, Адвентист сүмийн гишүүн байх

II. 5.6 заалтын дагуу ТУЗ-д ажиллах хүсэл эрмэлзэлтэй байх

III. 60 нас хүрээгүй байх

6.2 ТУЗ -ИЙН ГИШҮҮД СОНГОХ

I. ТУЗ-ийн гишүүдийг гишүүнчлэлтэй гишүүдээс сонгоно

II. ТУЗ-ийн гишүүдийг бүх гишүүдийн хурлаар 5.6, 5.7 заалтуудыг үндэслэн сонгоно.

III. Шинээр сонгогдсон ТУЗ -ийн гишүүд тангараг өргөснөөр баталгаажна.

IV. ТУЗ-ийн гишүүд: "Бурханы хүслээр Есүс Христийн элч болохоор дуудагдсан би, ASi Монгол холбооны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хүрээнд ASi Монгол холбооны эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн тулд, холбооны гишүүдийн нийтлэг эрх ашиг, эв нэгдлийг эрхэмлэн, Бурханаар удирдуулан ажиллахаа тангараглаж байна." хэмээн тангараг өргөнө.

V. Шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүд тангараг өргөснөөр өмнөх ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрх дуусгавар болно.

VI. ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгож болно.

6.3 ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЭРХ ҮҮРЭГ

1. Ерөнхийлөгч /Гадаад харилцаа давхар хариуцах/

a. ASi Монгол холбооны хөгжлийн асуудлаар ТУЗ-тэй зөвшилцөн гадаад, дотоод харилцаанд Холбоог төлөөлөх

b. ТУЗ-ийн хурлын шийдвэрийн дагуу гадаад харилцаа, хамтын ажиллагааны гэрээ, хэлцэл байгуулах

- c. Удирдах зөвлөлийн хурлыг даргалах
 - d. Өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Удирдах зөвлөлд чиглэл өгөх
 - e. Стратеги төлөвлөгөөг сурталчлах, хэрэгжүүлэх, үүрэг даалгавар өгөх
 - f. ТУЗ-ийн хурлаар стратеги төлөвлөгөөний төлөвлөлт, хэрэгжилтийг тогтмол хэлэлцүүлэх
2. Нарийн бичиг /Дотоод үйл ажиллагаа давхар хариуцах/
- a. Хурал зөвлөгөө, уулзалт бүрд протокол хөтлөх
 - b. Хурал зөвлөгөө, уулзалтад шаардлагатай зүйлсийг салбарын захирлуудтай хамтран бэлтгэх, зохион байгуулах
 - c. Ерөнхийлөгч үйл ажиллагаанд оролцох боломжгүй үед түүний эрх үүргийг орлох
 - d. Жилийн эцэст хариуцаж авсан салбарын тайлан мөн дараа жилийн төлөвлөгөөг ТУЗ-д танилцуулах
3. Санхүүч /Спонсор давхар хариуцах/
- a. Холбооны санхүүг бүрэн хариуцаж ажиллах
 - b. ТББ дүрэм журамд заасны дагуу цаг тухайд нь тайланг илгээх
 - c. Холбооны санхүүтэй холбоотой баримт бичгийг хариуцсан захирал албан тушаалтнаас шаардах, гаргуулах
 - d. Холбооны санхүүг улирал бүр ТУЗ-д тайлагнах
 - e. Үйл ажиллагааг ивээн тэтгэх Спонсор олох түүнтэй холбоотой бичиг баримтыг үйлдэх
 - f. Жилийн эцэст хариуцаж авсан салбарын тайлан мөн дараа жилийн төлөвлөгөөг ТУЗ-д танилцуулах
4. Баярын мэдээ болон холбооны сүнслэг байдал хариуцсан захирал
- a. Холбоо болон сүмүүдийн хамтын ажиллагаа дээр ажиллах
 - b. Жил бүр Баярын мэдээ түгээх төлөвлөгөө боловсруулах
 - c. Баярт мэдээтэй холбоотой арга хэмжээг зохион байгуулж гардан гүйцэтгэх
 - d. Холбооны сүнслэг байдлыг хариуцан ажиллах
 - e. Жилийн эцэст хариуцаж авсан салбарын тайлан мөн дараа жилийн төлөвлөгөөг ТУЗ-д танилцуулах
5. Гишүүд болон Орон нутаг хариуцсан захирал
- a. Гишүүдийн бүртгэл, хасалт хариуцан ажиллах
 - b. Орон нутгийн гишүүдтэй харилцаа холбоо тогтоох
 - c. Орон нутаг, шинэ гишүүд рүү чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах
 - d. Холбооны зүгээс зохион байгуулж буй үйл ажиллагаанд бүх гишүүдийг татан оролцуулах тал дээр ажиллах
 - e. Жилийн эцэст хариуцаж авсан салбарын тайлан мөн дараа жилийн төлөвлөгөөг ТУЗ-д танилцуулах

6. Төсөл хөтөлбөр болон Маркетинг хариуцсан захирал
 - a. Шинээр төсөл хөтөлбөр санаачлан хэрэгжүүлэх
 - b. Төсөл хөтөлбөрийг хариуцан ажиллах хүмүүсийг сонгох
 - c. Холбооны маркетингийн ажлыг хариуцан ажиллах
 - d. Маркетинг болон төсөл хөтөлбөртэй холбоотой төлөвлөгөө боловсруулах
 - e. Жилийн эцэст хариуцаж авсан салбарын тайлан мөн дараа жилийн төлөвлөгөөг ТУЗ-д танилцуулах
7. Шагнал урамшуулал болон зочид төлөөлөгч хариуцсан захирал
 - a. Үйл ажиллагааны шагнал урамшууллыг хариуцах
 - b. Гадаад болон дотоод зочид төлөөлөгчидтэй холбоотой ажлуудыг зохицуулах
 - c. Шагнал урамшуулалтай холбоотой төлбөр санхүүг ТУЗ-тэй хэлэлцэж шийдвэрлэх
 - d. Үйл ажиллагаа болохоос урьтаж оролцох шаардлагатай зочид төлөөлөгч рүү урьдчилан урилга явуулах
 - e. Жилийн эцэст хариуцаж авсан салбарын тайлан мөн дараа жилийн төлөвлөгөөг ТУЗ-д танилцуулах

6.4 ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙГ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1. Дараах тохиолдолд ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлнө. Үүнд:
 - a. Чөлөөлөгдөх хүсэлтээ ТУЗ-д бичгээр гаргасан бол
 - b. Нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон
 - c. Ял шийтгэл авсан
 - d. Эрүүл мэндийн болон хүндэтгэх бусад шалтгаанаар үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон
 - e. Гадаадад нэг жилээс дээш хугацаагаар явах болсон
 - f. Бүрэн эрхийн хугацаа дууссан
2. Дараах тохиолдолд ТУЗ-ийн гишүүнийг огцруулна. Үүнд:
 - a. Холбооны нэр хүндийг ноцтой унагасан үйлдэл хийсэн
 - b. Үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн гэж дүгнэж ТУЗ-ийн бусад гишүүд дэмжсэн
3. ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлөх, үүрэгт ажлаас нь огцруулах асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж олонхын саналаар шийдвэрлэж, нөхөн сонгох ажлыг ТУЗ зохион байгуулна.
4. Нөхөн сонгогдсон ТУЗ-ийн гишүүнийг ТУЗ-ийн бусад гишүүд батламжилна.

6.5 Ерөнхийлөгчийг түр орлох

1. Шаардлагатай тохиолдолд Ерөнхийлөгчийн үүргийг Удирдах зөвлөлийн гишүүн орлон гүйцэтгэж болно. Энэ шийдвэрийг Ерөнхийлөгчийн хүсэлтээр Удирдах зөвлөл гаргана.
2. Ерөнхийлөгч албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд Удирдах зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар Ерөнхийлөгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгчийг Удирдах зөвлөл сонгоно.

7-Р ЗҮЙЛ ГИШҮҮНЧЛЭЛИЙН ХУРААМЖ

7.1 Гишүүд ASi Монгол холбооны үйл ажиллагааг дэмжих зорилгоор заагдсан хураамжийг ASi Монгол холбооны дансанд тушаана.

7.2 Гишүүнчлэлийн төлбөрийг хоёр хуваан төлөх боломжтой бөгөөд уг тохиолдолд эхний төлбөрийг гишүүнээр бүртгүүлснээс хойш 6 сарын дотор, үлдэгдэл төлбөрийг дараагийн 6 сарын дотор төлөх үүрэгтэй.

7.3 Гишүүд болон ТУЗ-ийн гишүүдийн жилийн хураамж нь доорх байдалтай байна.

Төрөл	Жилийн хураамж
Компани	350,000₮
Энгийн гишүүн	280,000₮
Хүндэт гишүүн	700,000₮ түүнээс дээш
Ерөнхийлөгч	1,200,000₮
Нарийн бичиг	800,000₮
Санхүүч	600,000₮
Салбар хариуцсан захирал	450,000₮

7.4 ТУЗ-ийн хурлаар гишүүдийн хураамжийн дүнг хэлэлцэж батлах бөгөөд шаардлагатай гэж үзвэл Удирдах зөвлөл хуралдаж өөрчлөлт оруулж болно.

8-Р ЗҮЙЛ ГИШҮҮНЧЛЭЛИЙГ ЦУЦЛАХ, СЭРГЭЭХ:

8.1 Гишүүнчлэлийг доорх нөхцлүүдэд цуцална.

- a. Өөрийн хүсэлтээр
- b. Гишүүнчлэлийн төлбөрөө 7.2-т заасан хугацаанд төлөөгүй
- c. ASi холбооны дүрэм зөрчсөн
- d. Адвентист сүмийн үнэт зүйлд харшилсан үйлдэл гаргасан

8.2 Гишүүнчлэлээ цуцалсан эсвэл хасагдсан гишүүн гишүүнчлэлээ сэргээх хүсэлт гаргасан нөхцөлд ТУЗ зөвшилцөж гишүүнчлэлийг сэргээж болно.

9-Р ЗҮЙЛ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД:

9.1 Бүх гишүүдийн хурлаар эсвэл Удирдах зөвлөл дангаар хуралдаж дүрэмд өөрчлөлт, засвар оруулж болно.

9.2 Дүрэмд өөрчлөлт засвар оруулах нөхцөлд нарийн бичиг протокал хөтөлж баримтжуулна.

9.3 Дүрэмд өөрчлөлт засвар оруулах нөхцөлд 5.7 заалтыг баримтална.

10-Р ЗҮЙЛ ХОЛБООГ ТАТАН БУУЛГАХ:

8.1 Хэрэв ASi Монгол холбоо нь хоёр жилийн хугацаанд үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж чадаагүй, гишүүдийн оролцоо байхгүй нөхцөлд холбоог татан буулгаж NSD ASi холбоонд албан бичиг хүргүүлж үйл ажиллагааг зогсооно.

8.2 Хэрэв ASi Монгол холбоо нь санхүүгийн хувьд үйл ажиллагаагаа хэвийн явуулах чадамжгүй болбол холбоог татан буулгаж NSD ASi холбоонд албан бичиг хүргүүлж үйл ажиллагааг зогсооно.

8.3 Хэрэв ASi Монгол холбооны Удирдах зөвлөлийн орон тоо бүрдэхгүй нөхцөлд холбоог татан буулгаж NSD ASi холбоонд албан бичиг хүргүүлж үйл ажиллагааг зогсооно.



**БИДЭНТЭЙ
ХОЛБОГДОХ**



+976 95076599



asimongolia@gmail.com



ASi Mongolia



www.asi-mongolia.com